



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/129

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.а, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавирус (COVID-19) цартахлын өвчлөлийн илрүүлэг шинжилгээнд шаардагдах 1000 (нэг мянга) ширхэг түргэвчилсэн оношлуурын зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардал 14,967,000 (арван дөрвөн сая есөн зуун жаран долоон мянга) төгрөгийг Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

3.Түргэвчилсэн оношлуур худалдан авах талаар аж ахуйн нэгжүүдээс үнийн санал авч, худалдан авалт хийхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100281

Аймгийн Засаг даргын 2021 оны 03
дугаар сарын 22 ны өдрийн 41729 дүгээр
захирамжийн хавсралт



КОВИД-19 ЦАРТАХЛЫН ӨВЧЛӨЛИЙН ИЛРҮҮЛГИЙН ШИНЖИЛГЭЭНД
ШААРДАГДАХ ТҮРГЭВЧИЛСЭН ОНОШЛУУРЫН ТООЦОО

| Д/д | Оношлуурын төрөл | Тоо ширхэг | Нэг бүрийн үнэ | Бүгд үнэ |
|------------|--------------------------------|------------|----------------|-------------------|
| 1 | Ковид-19 түргэвчилсэн оношлуур | 500 | 14934 | 7,467,000 |
| 2 | | 1250 | 6000 | 7,500,000 |
| Дүн | | | 20934 | 14,967,000 |

-оОо-